

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

23.	Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/	115
24.	Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	128
25.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай	128
26.	Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	129
27.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	129
28.	Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	130
29.	Хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	131
30.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	131
31.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үсийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	151
32.	Ариун цэврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	152
33.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	153
34.	Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	153

35.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	154
36.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	155
37.	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	157
38.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	160
39.	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	160

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

40.	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 67	161
41.	Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 68	162
42.	Монгол Улсын Их Хурлын гиншүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 72	162
43.	“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтооид өөрчлөлт оруулах тухай	Дугаар 73	163
44.	Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай	Дугаар 74	163

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

45.	Орон тооны бус зөвлөхөөр томилох тухай	Дугаар 218	164
46.	Дипломат цол хүргээх тухай	Дугаар 223	165
47.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 224	165
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
48.	Жагсаалт батлах тухай	Дугаар 131	166
49.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 135	187
50.	Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 136	187

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХҮНСНИЙ ТУХАЙ**  
/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Хүнсний тухай хууль тогтоомж

2.1. Хүнсний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Үндэсний аюулгүй байдлын тухай<sup>2</sup>, Хүнсний бүтээгдэхүүний

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Үндэсний аюулгүй байдлын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

аюулгүй байдлыг хангах тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хүнс” гэж хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийг дэмжин хамгаалахад шаардагдах хүнсний түүхий эд, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн, ундны усыг;

3.1.2.“хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршилаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг;

3.1.3.“хүнсний чанар” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний стандарт, техникийн зохицуулалтын болон хэрэглээний шаардлага хангасан байдлыг;

3.1.4.“хүнсний эрүүл ахуй” гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.5-д заасныг;

3.1.5.“органик хүнс” гэж мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг;

3.1.6.“стратегийн хүнс” гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг;

3.1.7.“шим тэжээллэг хүнс” гэж хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх уураг, өөх тос, нүүрс ус, эрдэс бодис, амин дэм болон ашигтай бичил биетний зохистой агууламжтай хүнсийг;

3.1.8.“шинэ технологиор үйлдвэрлэсэн” гэж Монгол Улсад урьд өмнө нь үйлдвэрлэж, практикт хэрэглэж байгаагүй, шинжлэх



ухаан, технологийн дэвшилтэт аргаар үйлдвэрлэсэн, эсхүл шинэ технологийг импортлон үйл ажиллагаандaa нэвтрүүлсэн, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй нь батлагдсан, хуульд заасны дагуу эрхийн хамгаалалт хийгдсэний;

3.1.9."хүнсний нэмэлт" гэж дангаараа бүтээгдэхүүн, эсхүл хүнсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж чаддаггүй, тэжээллэг чанаргүй, амт, үнэр, өнгө оруулах, биежүүлэх, сийрэгжүүлэх, хадгалах хугацааг уртасгах болон технологи ажиллагааг хурдасгах зорилгоор хүнсний үйлдвэрлэлийн явцад зориудаар нэмдэг бодис, хольцыг;

3.1.10."бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө" гэж хүнсийг боловсруулах шатанд үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэдэг бичил биетэн, тэдгээрийн биомасс бэлдмэлийг;

3.1.11."хүнсний сүлжээ" гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.6-д заасныг;

3.1.12."хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч" гэж хүнсний сүлжээнд хамаарах үйл ажиллагааны аль нэг, эсхүл хэд хэдэн үйл ажиллагаа эрхлэдэг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийг;

3.1.13."зохистой дадал" гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.19-4.1.21-д заасныг.

#### **4 дүгээр зүйл.Хүнсний аюулгүй байдлыг хангах зарчим**

4.1.Хүнсний аюулгүй байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

4.1.1.хүнсний хангамж тогтвортой, хүртээмжтэй байх;

4.1.2.хүнс нь хүний эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээллэг найрлагатай байх;

4.1.3.хүнс нь хүний эрүүл мэнд, амь насанд гэм хор учруулахааргүй байх;

4.1.4.хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх.



## ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНСНИЙ ХАНГАМЖ

### 5 дугаар зүйл.Хүнсний хангамжийг тодорхойлох

5.1. Монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасны дагуу баталсан зохистой хэмжээг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний хангамжийг тодорхойлно.

### 6 дугаар зүйл.Хүнсний нөөц

6.1. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

6.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.4. Засгийн газар хүнсний эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлаас хамааран энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож болно.

6.5. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.

6.6. Хүн амын эмзэг бүлгийг тодорхойлох аргачлал гаргаж, судалгаа хийх, тэдний хүнсний хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.

6.7. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.



6.8.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.7-д заасны дагуу тогтоосон хэмжээнд багтаан Засгийн газраас баталсан журмын дагуу стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгоно.

6.9.Энэ хуулийн 6.8-д заасан зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар<sup>3</sup> зохицуулна.

6.10.Хүнсний улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

6.11.Гадаадын зээл, тусlamжаар хүнс авахтай холбогдсон харилцааг Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай хуулиар<sup>4</sup> зохицуулна.

## **7 дугаар зүйл.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс**

7.1.Удамшлын мэдээллийн шинэ хослол бүхий аливаа амьд организмаас гарган авсан хүнсийг хувиргасан амьд организмаас гаралтай хүнс гэнэ.

7.2.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14.1-д заасан журмын дагуу хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэнэ.

7.3.Хувиргасан амьд организмаас гаралтай импортын хүнсний талаар хүнсний хяналтыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага /цаашид “хяналтын байгууллага” гэх/ болон биоаюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага цахим хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

7.4.Гадаадын зээл, тусlamжаар хувиргасан амьд организмаас гаралтай хүнс авахыг хориглоно.

## **8 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал**

8.1.Төрөөс дор дурдсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж болно:

<sup>3</sup>Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



8.1.1.стратегийн хүнсний үйлдвэрлэл;  
8.1.2.дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний импорт;

8.1.3.хүүхдийн хоол тэжээл болон органик хүнсний үйлдвэрлэл;

8.1.4.хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтэний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөн үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэл;

8.1.5.үйл ажиллагаандаа зохистой дадал, энэ хуулийн 10.2.1-д заасан хяналтыг нэвтрүүлсэн;

8.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан;

8.1.7.дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

8.2.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд олгох урамшуулалтай холбогдсон харилцааг Тариалангийн тухай хуулиар<sup>5</sup> зохицуулна.

8.3.Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно.

8.4.Энэ хуулийн 8.1.2-т заасан өргөн хэрэглээний хүнсний жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.5.Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.

## 9 дүгээр зүйл.Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах

9.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

<sup>5</sup>Тариалангийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



9.1.1.хүн амын хоол тэжээлийн үндэсний хэмжээний судалгааг таван жил тутамд гаргаж, дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх;

9.1.2.энэ хуулийн 9.1.1-д заасан судалгаанд үндэслэн хүн амын зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

9.1.3.шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журам батлах.

9.2.Зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хүний бие махбодид зайлшгүй шаардлагатай биологийн идэвхт хүчин зүйлээр баяжуулах, эсхүл илүүдэл бодисын агууламжийг багасган зохицуулж болно.

9.3.Хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХҮНСНИЙ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ТАВИХ ШААРДЛАГА**

**10 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд  
тавих шаардлага**

10.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавина:

10.1.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах;

10.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

10.1.3.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр сууринуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх;

10.1.4.үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх;

10.1.5.боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх;

10.1.6.үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх;

10.1.7.хуульд заасан бол тусгай зөвшөөрөл авсан байх.

10.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дараах хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно:

10.2.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.3-т заасан аюулын дүн шинжилгээ ба эгзэтгэй цэгийн хяналт;

10.2.2.хүнсний чанарын удирдлага;

10.2.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын удирдлага.

10.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн<sup>6</sup> 6.1.3-т заасны дагуу баталсан жагсаалтад орсноос бусад пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглоно.

## **11 дүгээр зүйл.Хүнс экспортлох, импортлоход тавих шаардлага**

11.1.Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд<sup>7</sup> зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

11.2.1.экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байх;

11.2.2.импортлох хүнс нь зохистой дадал, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх;

<sup>6</sup>Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны 25 дугаарт нийтигэдсэн.

<sup>7</sup>Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтигэдсэн.



11.2.3.импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх;

11.2.4.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх.

11.3.Импортлогч энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлээгүй, олон улсад хэрэглэдэг таних тэмдэг, тэмдэглэгээгүй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө /цаашид “өсгөврийн хөрөнгө” гэх/, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, энэ хуулийн 7.2-т заасны дагуу бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг импортлохыг хориглоно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ,  
БАТАЛГААЖУУЛАЛТ**

**12 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт**

12.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмыг Засгийн газар батална.

12.3.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

**13 дугаар зүйл.Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт**

13.1.Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт дараах үйл ажиллагаагаар хэрэгжижээ:

13.1.1.зах зээл дэх хүнсний чанар, шим тэжээллэг байдалд хийх тандалт судалгаа;

13.1.2.хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт;

13.1.3.хүнс экспортлох, импортлоход тавих гаалийн болон хорио цээрийн хяналт;

13.1.4.стратегийн хүнс экспортлох, импортлох тохиолдолд энэ хуулийн 6.8-д заасан зөвшөөрөл олголт.

13.2.Энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан хяналтыг холбогдох хуулиар зохицуулна.

13.3.Хуульд заасан хүрээ, хязгаарын дотор мэргэжлийн холбоо болон бусад төрийн бус байгууллага, иргэн хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно.

#### **14 дүгээр зүйл.Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо**

14.1.Төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангахад дараах чиглэлээр оролцно:

14.1.1.хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

14.1.2.хэрэглэгч болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрхийг хамгаалах асуудлаар саналаа төрийн болон нутгийн захиргааны байгууллагад уламжлах;

14.1.3.хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хооллолтыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

14.1.4.хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдох судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх.

#### **15 дугаар зүйл.Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг**

15.1.Хэрэглэгч дараах оролцогоор хүнсний чанар, эрүүл ахуй, хангамж, хүртээмжийг хангах үйл ажиллагааг дэмжинэ:

15.1.1.гарал үүсэл нь тодорхой, баталгаатай хүнс сонгон хэрэглэж, эрүүл мэндээ хамгаалах;

15.1.2.нас, хүйс, эрүүл мэнд, хөдөлмөр, байгаль, цаг уурын нөхцөлд тохируулан өөрийн бие махбодид зайлшгүй шаардлагатай шим тэжээллэг бодисыг зохистой харьцаагаар агуулсан хүнс хэрэглэх талаар мэдлэг олж авах, арга барил эзэмших;



15.1.3.хүнсийг зориулалт, зааврын дагуу хадгалах, бэлтгэх, боловсруулах, өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ хоол хүнснээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх зөв дадалд хэвшүүлэх.

### 16 дугаар зүйл.Бүртгэл

16.1.Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын бүртгэлд бүртгэнэ.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.3.Хүнсэн дэх цацрагийн түвшинг тодорхойлох, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар<sup>8</sup> зохицуулна.

16.4.Органик хүнсийн холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

### 17 дугаар зүйл.Баталгаажуулалт

17.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага болон баталгаажуулалт авсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, нийтэд мэдээлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

### 18 дугаар зүйл.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл

18.1.Монгол Улсад хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл гэх”/ Засгийн газрын дэргэд ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга Монгол Улсын Ерөнхий сайд байна.

<sup>8</sup>Цөмийн энергийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

18.2.Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэг бүхий нарийн бичгийн дарга орон тооны байна.

18.3.Үндэсний зөвлөл нь мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багтай байж болно.

18.4.Засгийн газар Үндэсний зөвлөлийн дүрэм, ажиллах журмыг баталж, бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

18.5.Үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.5.1.хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргаж, тэдгээрийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

18.5.2.хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

18.5.3.хүнсний аюулгүй байдлын талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлж, чиглэл өгөх;

18.5.4.хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;

18.5.5.хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын талаарх тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

19.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

19.1.1.энэ хуулийн 6.8-д заасан зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хэмжээнээс хэтрүүлэн стратегийн хүнс экспортолсон, импортолсон хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг дөчөөс дөчин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортож, хууль бусаар олсон орлого болон хүнсийг хураах;



19.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.6, 10.1.7-д заасныг зөрчсөн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучас дэч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, үйл ажиллагааг нь зогсоох;

19.1.3.энэ хуулийн 10.1.5-д заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, үйл ажиллагааг нь түр зогсоох;

19.1.4.энэ хуулийн 10.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, үйл ажиллагааг нь зогсоох;

19.1.5.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн экспортлогч, импортлогчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөчин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортож, хүнсийг хураах.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулсан нь буруутай этгээдийг учруулсан хохирлоо нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

20.1.Энэ хуулийг 2013 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

20.2.Энэ хуулийн 10.1.4 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нийгмийн хамгаалал,” гэсний дараа “хүнсний аюулгүй байдал,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “д” дэд заалтын “хүнсний хангамж, илчлэг” гэснийг “хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээлийн болон чанар, эрүүл ахуйн үзүүлэлт;” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын “хөдөө аж ахуйг хөгжүүлэх” гэсний өмнө “хүнсний аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн заалтын “а” дэд заалтын “хэрэгжүүлэх үндсэн дээр” гэсний дараа “хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

#### 1/3 дугаар зүйлийн 3.4.10 дахь заалт:

"3.4.10.хүнсний аюулгүй байдал."

#### 2/18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалт:

"18.1.9.хүнсний аюулгүй байдлын."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.25 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.1.25.“биологийн идэвхт бүтээгдэхүүн” гэж хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмжих, зайлшгүй шаардлагатай эрдэс бодисоор нөхөх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнийг.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДАВС ИОДЖУУЛЖ ИОД ДУТЛААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1.Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрх бүхий улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

“11.1.1.энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг долоогоос арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортогх;

11.1.2.энэ хуулийн 8.2-т заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортогх;

11.1.3.энэ хуулийн 8.3, 8.4, 9.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортогх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хучин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1999 оны 10 дугаар сарын 07-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндэсний хууль<sup>1</sup>, Үндэсний аюулгүй байдлын тухай<sup>2</sup>, Хүнсний тухай, Усны тухай<sup>3</sup>, Малын удмын сан, эрүүл мэндийг

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Үндэсний аюулгүй байдлын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Усны тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

хамгаалах тухай<sup>4</sup>, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай<sup>5</sup>, Тариалангийн тухай<sup>6</sup>, Ургамал хамгааллын тухай<sup>7</sup>, Төрийн хяналт шалгалтын тухай<sup>8</sup>, Ариун цэврийн тухай<sup>9</sup>, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль<sup>10</sup>, энэ хууль, эдгээр хуулттай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль хүнсний түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошголох зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатанд үйлчилнэ.

3.2.Ургамал хамгааллын тухай, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулиар зохицуулснаас бусад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдон үүсэх харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.3.Энэ хууль мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээл, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бордооны аюулгүй байдлыг хангахтай холбогdon үүсэх харилцаанд үйлчилнэ.

3.4.Энэ хууль иргэн хувийн хэрэгцээндээ зориулан хүнс бэлтгэх, боловсруулах, хадгалах харилцаанд үйлчлэхгүй.

### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

<sup>4</sup>Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтгэгдсэн.

<sup>5</sup>Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтгэгдсэн.

<sup>6</sup>Тариалангийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 19 дугаарт нийтгэгдсэн.

<sup>7</sup>Ургамал хамгааллын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 44 дугаарт нийтгэгдсэн.

<sup>8</sup>Төрийн хяналт шалгалтын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтийгдсэн.

<sup>9</sup>Ариун зориийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 7 дугаарт нийтгэгдсэн.

<sup>10</sup>Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 25 дугаарт нийтгэгдсэн.



4.1.1.“хүнсний бүтээгдэхүүн” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.1-д зааснаас гадна савласан ус, бүх төрлийн ундаа, бохь, хүнсний нэмэлтийг;

4.1.2.“хүнсний түүхий эд” гэж мал, амьтан, ургамал, эрдсийн болон бусад гаралтай түүхий эд, түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулахад хэрэглэдэг усыг;

4.1.3.“хүнсний нэмэлт” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.9-д заасныг;

4.1.4.“хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй байхыг;

4.1.5.“хүнсний эрүүл ахуй” гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүхий л нөхцөл, шаардлагыг;

4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;

4.1.7.“анхан шатны үйлдвэрлэл эрхлэх” гэж ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг тариалах, хураах, бэлтгэх, мал, амьтан, загас өсгөх, үржүүлэх, мал бэлтгэх, төхөөрөх, түүхий сүү бэлтгэх, боловсруулах, байгалийн гаралтай жимс жимсгэнэ, ургамлыг түүх, тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг;

4.1.8.“хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс” гэж машин техник, тоног төхөөрөмж, зоорь, агуулах, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол зэрэг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдан борлуулахад ашиглаж, хэрэглэж байгаа зүйлийг;

4.1.9.“бохирдуулагч” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд өөрт нь агуулагддаг, эсхүл хүнсний сүлжээний үйл ажиллагааны явцад, түүнчлэн хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлийн бохирдоос бий болсон хими, физик, биологийн хүчин зүйлсийг;

4.1.10.“пестицидийн үлдэгдэл” гэж Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн<sup>11</sup> 3.1.5-д заасан бодисын үлдэгдлийг;

<sup>11</sup>Химийн хорт болон аюулгай бодисын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

4.1.11.“малын эм, бэлдмэлийн үлдэгдэл” гэж мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, түүний бохирдол, тэдгээрийн малын биед орж хувирсан нэгдлийн үлдэгдлийг;

4.1.12.“хадгалах хугацаа” гэж өгөгдсөн хугацаанд зохих нөхцөлийн дагуу хадгалж, хэрэглэхэд тухайн хүнсний бүтээгдэхүүний чанар хамгийн сайн түвшинд байх, тухайн хугацаа хэтрэхэд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдахгүй боловч чанарын үзүүлэлт нь муудах буюу өөрчлөгдөх хугацааг;

4.1.13.“хэрэглэж дусах хугацаа” гэж өгөгдсөн хугацаанд тухайн хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байх, тухайн хугацаа өнгөрөхөд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдах хугацааг;

4.1.14.“тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний бүтээгдэхүүн” гэж нярай, бага насны хүүхдийн болон сувиллын хоолны дэглэм, шаардлагад нийцүүлэн боловсруулсан түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.15.“хуурамч хүнсний бүтээгдэхүүн” гэж хүнсний бүтээгдэхүүний орц найрлагад зайлшгүй орох зүйлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хийгээгүй, хассан, эсхүл өөр зүйлээр орлуулсан, түүнчлэн муудсан, чанараа алдсан бүтээгдэхүүний өнгө үзэмжийг засах, жин хэмжээг нэмэх, хасах зэргээр бодит байдлыг нь нуун далдалсан, өөрчилсөн хүнсний бүтээгдэхүүнийг;

4.1.16.“хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.12-т заасныг;

4.1.17.“бүтээгдэхүүний цуврал” гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг;

4.1.18.“хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт” гэж хүнсэн дэх физик, хими, биологийн бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг;

4.1.19.“хөдөө аж ахуйн зохистой дадал” гэж мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд тэдгээрийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүх нөхцөл, үйл ажиллагааг;

4.1.20.“эрүүл ахуйн зохистой дадал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйл ажиллагааг;



4.1.21.“үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж үйлдвэрлэлийн бүх үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, хяналт, үйл ажиллагааг.

#### **5 дугаар зүйл.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим**

5.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;

5.1.2.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцах;

5.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлох;

5.1.4.хяналт шалгалт нь эрсдэлд суурилсан байх;

5.1.5.хүнсний зориулалтаар бэлтгэх мал, амьтан, таримал ургамал эрүүл байх.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНСНИЙ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ**

#### **6 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл**

6.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьялах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллага / цаашид “хяналтын байгууллага” гэх /-д мэдээлнэ:

6.1.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг;

6.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журам.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан маягтын загварыг хяналтын байгууллага батална.

6.3. Энэ хуулийн 6.5-д зааснаас бусад тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 6.1-д заасны дагуу мэдээлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж болно.

6.4. Хяналтын байгууллага энэ хуулийн 6.1-д заасан мэдээлэлд тулгуурлан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөнө.

6.5.Хяналтын байгууллага дор дурдсан үйлдвэрлэлийг шинээр эрхлэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Хүнсний тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана:

6.5.1.мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

6.5.2.өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

6.5.3.нярай, бага насы болон цэцэрлэгийн хүүхэд, өрөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл.

6.6.Хяналтын байгууллага энэ хуулийн 6.5-д заасан хугацаанд дүгнэлт гаргаагүй тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйлдвэрлэлээ эхлүүлж эрхтэй.

6.7.Энэ хуулийн 6.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг техникийн зохицуулалтад тусгана.

6.8.Уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 6.5 дахь хэсэг хамаарахгүй.

6.9.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 6.1-д заасан мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа 15 хоногийн дотор хяналтын байгууллагад мэдэгднэ.

## **7 дугаар зүйл.Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр**

7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:

7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;



7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;

7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал.

7.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршилаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага хамтран батална.

7.3.Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаандаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг илрүүлэн тогтоох, үнэлэн дүгнэх, хянан шалгах зорилгоор аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж болно.

7.4.Энэ хуулийн 7.1, 7.3-т заасан зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийг хяналтын байгууллага гаргана.

## **8 дугаар зүйл.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах**

8.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүний эрүүл мэндэд серөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл тэдгээрийг хүнсний сүлжээнээс буцаан авна.

8.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээнээс татан авна:

8.2.1.хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл гарсан;

8.2.2.тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг хяналт шалгалтаар тогтоосон;

8.2.3.тухайн импортолсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулын талаарх сэрэмжлүүлэг олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн.

8.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үндэслэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан тохиолдолд

хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ тухайгаа нэн даруй хяналтын байгууллага, хэрэглэгчид болон тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан хүнсний сүлжээний дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгднэ.

8.4.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгална.

8.5.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 8.2-т заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ татан авсан тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрийг гартал хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авсан он, сар, өдрийг тэмдэглэн тухайн түүхий эд, бүтээгдэхүүнийг тусгаарлан битүүмжилж хадгална.

8.6.Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу устгана.

8.7.Буцаан болон татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу дахин боловсруулж болно.

8.8.Энэ хуулийн 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн болон ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

8.9.Энэ хуулийн 8.2, 8.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

8.10.Энэ хуулийн 8.2, 8.6, 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмыг Засгийн газар батална.

8.11.Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ.



## **9 дүгээр зүйл.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл**

9.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг энэ хуулийн 9.5-д заасан журмын дагуу хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хөтөлнө.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бүртгэлийг ашиглан хүнсний сүлжээн дэх эрсдэл гарсан үе шатыг тогтооно.

9.3.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасныг хэрэгжүүлсний үр дүнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтооно.

9.4.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 9.1-д заасан бүртгэлийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа дууссанаас хойш 30-аас доошгүй хоногийн хугацаанд, эсхүл хадгалах хугацаа дууссанаас хойш нэгээс доошгүй жилийн хугацаанд тус тус хадгална.

9.5.Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлалыг хяналтын байгууллага батална.

## **10 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг**

10.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүргийг хүлээнэ:

10.1.1.хүнсний сүлжээний бүх үе шатанд энэ хууль, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлж, буруутай үйл ажиллагааныхаа улмаас учирсан хохирлыг хариуцах;

10.1.2.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэрэгжүүлэх;

10.1.3.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх;

10.1.4.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ буцаан болон татан авах;

10.1.5.үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх, урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах;

10.1.6.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах;

10.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцааг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах;

10.1.8.энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтан халдварт өвчинеөр өвчилсөн, эсхүл ийм өвчтөнг асарсан тохиолдол бүрд тухайн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах;

10.1.9.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах;

10.1.10.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний зураасан кодыг хэрэглэх.

10.2.Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.3.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно:

10.3.1.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд серөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

10.3.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх;

10.3.3.хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНД  
ТАВИХ ШААРДЛАГА**

**11 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх  
хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн**

11.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үзнэ:

11.1.1.зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бохирдуулагч агуулсан;

11.1.2.хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан;

11.1.3.эрүүл ахуй, ариун цэврийн горим зөрчин хүнсний сүлжээний дараагийн үе шатанд гаргасан;

11.1.4.Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй хувиргасан амьд организмаас гарган авсан;

11.1.5.Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр ёсгөврийн хөрөнгийг ашиглаж үйлдвэрлэсэн;

11.1.6.олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аюулгүйн шаардлагад нийцсэн ионжуулагч цацрагийн боловсруулалт хийснээс бусад цацрагаар бохирдсон;

11.1.7.хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн.

**12 дугаар зүйл.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний  
сав, баглаа боодол, шошго**

12.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалыар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна.

12.2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12.3. Энэ хуулийн 12.2-т зааснаас бусад харагдах байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана.

12.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго дараах мэдээллийг агуулсан байна:

- 12.4.1. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр;
- 12.4.2. ўйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- 12.4.3. хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар;
- 12.4.4. ўйлдвэрлэсэн он, сар, өдөр;
- 12.4.5. хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа;
- 12.4.6. хадгалах нөхцөл;
- 12.4.7. тэжээллэг чанар, орц, найрлага;
- 12.4.8. хэрэглэх арга;
- 12.4.9. гаж нөлөө, хориглох заалт.

12.5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго, дагалдах хуудсанд энэ хуулийн 12.3, 12.4-т зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:

12.5.1. тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний зориулалт, найрлага болон хэрэглэх заавар;

12.5.2. хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гүйцэд боловсруулах аргачлал;

12.5.3. хүнсний нэмэлт, органик хүнс, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг тавьсан байх.

12.6. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл Монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна.

12.7. Дараах тохиолдолд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буруу шошголсон гэж үзнэ:

12.7.1. шошго худал мэдээлэл агуулсан;  
12.7.2. тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн өөр хүнсний нэрээр бичигдсэн;

12.7.3. өөр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол ашиглан шошгыг дуурайлгаж хуурамчаар үйлдсэн;



12.7.4.энэ хуулийн 12.4, 12.5.2-т заасан шошгод тавьсан шаардлагыг хангаагүй;

12.7.5.энэ хуулийн 12.5.1-д заасан мэдээллийг монгол хэлээр бичээгүй, энэ хуулийн 12.5.3-т заасны дагуу Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг шошгод тавиагүй;

12.7.6.унших боломжгүй, ойлгомжгүй үг, өгүүлбэр, он, сар, өдөр бичигдсэн;

12.7.7.ионжуулагч цацрагийн боловсруулалт хийсэн тэмдэглэгээгүй.

12.8.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодолдээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна.

12.9.Хүнсний шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын техникийн зохицуулалт, стандартаар зохицуулж болно.

### **13 дугаар зүйл.Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн**

13.1.Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд сууринсан хяналт шалгалтыг хийнэ.

13.2.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бус нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна.

13.3.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шошгон дээр нь заасан нөхцөлийн дагуу хадгална.

13.4.Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу импортлох болон экспортлох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд холбогдох хяналт шалгалт хийнэ.

13.5.Мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлогч эхний удаа импортлох тохиолдолд түүний

нэр, төрөл, бүс нутаг, улс, үйлдвэрлэгчийн нэрийг ачилт хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

13.6.Хяналтын байгууллага энэ хуулийн 13.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт шалгалт хийнэ.

13.7.Хяналтын байгууллага гадаадын зээл, тусlamжаар авах болон энэ хуулийн 6.5-д заасан өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх хяналт шалгалтыг хийж болно.

13.8.Энэ хуулийн 13.6, 13.7-д заасан ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг Засгийн газар батална.

#### **14 дүгээр зүйл.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн**

14.1.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага хамтран батална.

14.2.Эхний удаа импортолсон болон дотооддоо үйлдвэрлэсэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хяналтын байгууллага хяналт шалгалт хийнэ.

14.3.Энэ хуулийн 14.1-д заасан журмын дагуу эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглоно.

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААРХ ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ, ХЯНАЛТ**

#### **15 дугаар зүйл.Үндэсний лавлагaa лаборатори**

15.1.Хяналтын байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагaa лаборатори ажиллана.



15.2.Үндэсний лавлагаа лаборатори дараах чиг үүрэгтэй байна:

15.2.1.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд тандалт судалгаа, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад тухай бүрд хүргүүлэх;

15.2.2.энэ хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, удирдах;

15.2.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

15.2.4.эрсдэлийн үнэлгээ хийх удирдамж баталж, эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 16.1-д заасан эрсдэлийн үнэлгээний баг /цаашид “баг” гэх /-аар гүйцэтгүүлэх, багийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, үнэлгээний дүнг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;

15.2.5.лабораторийн шинжилгээний шинэ аргачлал боловсруулах, энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах, аргын баталгаажуулалт хийх;

15.2.6.энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах;

15.2.7.хүнсний аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт, эрүүл ахуйн болон ариун цэврийн арга хэмжээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн төсөлд санал өгөх;

15.2.8.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжлэх, шаардлагатай бол онцгой байдлын болон гамшгийн үед авсан дээжид шинжилгээ хийх.

15.3.Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцно.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан лаборатори шинжилгээний дүнгээ мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.

15.5.Энэ хуулийн 15.1-д заасан Үндэсний лавлагаа лаборатори болон багийн ажиллах журмыг Засгийн газар батална.



## 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх

16.1. Баг дараах зорилгоор эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан эрсдэлийн үнэлгээг хийнэ:

16.1.1. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим алдагдсанаас үүссэн аюулыг үнэлэх;

16.1.2. эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал, амьтанд учирч болзошгүй эрсдэлийн нөлөөллийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг тогтоох.

16.2. Үндэсний лавлагaa лаборатори энэ хуулийн 16.1-д заасан багийг ашиг сонирхлын зөрчилгүй, дадлага туршлагатай, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд болон бусад салбарын шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтнээс тухай бүрд нь бүрдүүлнэ.

16.3. Баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.3.1. шинжлэх ухаанаар нотлогдсон мэдээллийг ашиглан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалаар ил тод, бие даасан байдлаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд агуулагдаж болзошгүй бохирдлын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх;

16.3.2. эрсдэлийн үнэлгээ хийхэд судалгаа, шинжилгээний нотолгоо хангалттай бус, түүнчлэн хүний эрүүл мэндэд аюул учруулахуйц нөхцөл үүссэн тохиолдолд олон улсын байгууллага, бусад улсын боломжит мэдээллийг үндэслэн холбогдох арга хэмжээг авах;

16.3.3. үүссэн аюулыг арилгах, эрсдэлийн үр дагаврыг бууруулах талаар зөвлөмж гаргах;

16.3.4. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

16.4. Эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэслэн эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтыг холбогдох төрийн байгууллага хэрэгжүүлнэ.

## 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

17.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



17.1.1.хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулах;

17.1.2.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох;

17.1.3.мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээл, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бордооны аюулгүй байдалд тавих шаардлагыг тогтоох.

17.2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.2.1.тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, энэ хуулийн 6.5.3-т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлд тавих шаардлагыг тогтоох;

17.2.2.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох;

17.2.3.хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох;

17.2.4.хоол хүнснээс шалтгаалсан байнгын болон өвчлөлийн үеийн тандалт судалгаа хийж, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг олон улсын мэдээллийн сүлжээнд болон нийтэд мэдээлэх.

## **18 дугаар зүйл.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт**

18.1.Хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд дараах байдаар хяналт тавина:

18.1.1.хүнсний сүлжээний үе шат болон үйл ажиллагааны явцад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн шалтгааныг тогтоох, таслан зогсоох, нийтэд шуурхай мэдээлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөгөө өгөх, хяналт шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

18.1.2.хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх;

18.1.3.импортын болон дотоодод үйлдвэрлэсэн хүнс холбогдох техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, эрсдэлд сууринсан тандалтыг зохион байгуулах;

18.1.4.зохистой дадлыг нэвтрүүлэх болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлд хяналт тавих;

18.1.5.хүнсний аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахдаа багийн гаргасан эрсдэлийн үнэлгээ, техникийн зөвлөмжид тулгуурлах;

18.1.6.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, зохих өөрчлөлт, хөдөлгөөн хийх, төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчид шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх.

18.2.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>4</sup>.3-т заасан эрсдэлд сууринсан хяналт шалгалтын давтамж тухайн үйлдвэрлэлийн онцлог, үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн ангилалтай уялдсан байна.

18.3.Хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын нэгжтэй байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

### 19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл улсын байцаагч дор дурдсан захирагааны шийтгэлийг ногдуулна:

19.1.1.хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх болон хуурамч хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдан борлуулсан, түүгээр үйлчилгээ үзүүлсэн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



19.1.2.энэ хуульд заасны дагуу мэдээлээгүй болон зөвшөөрөл аваагүй, түүнчлэн хяналтын байгууллагаас үйл ажиллагааг нь хориглосон бөгөөд үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулах тухай шийдвэр гараагүй байхад үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөчин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, үйл ажиллагааг нь зогсоо;

19.1.3.хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, түүнчлэн хуурамч болон шошгод тавих шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татах аваагүй хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наймаас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах;

19.1.4.энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг нэвтрүүлээгүй, түүнчлэн хүнсний бүтээгдэхүүн бүрд ул мөр мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, үйл ажиллагааг нь зогсоо;

19.1.5.устгахаар шийдвэрлэсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулсан, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулсан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөчин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тортож, тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах;

19.1.6.хэрэглэж дуусах хугацаа нь хэтэрсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан, уг хугацааг өөрчлөн засварласан хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах;

19.1.7.энэ хуулийн 14.3-т заасныг зөрчин хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

19.1.8.эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлсэн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

19.2.Энэ хуулийн 19.1.1, 19.1.3, 19.1.5-19.1.8-д заасан зөрчлийг давтан гаргасан этгээдийн үйл ажиллагааг нь зогсоо буюу зөвшөөрлийг хүчингүй болгоно.

19.3.Энэ хуулийн 19.1, 19.2-т заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулсан нь буруутай этгээдийг учруулсан хохирлоо нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

20.1.Энэ хуулийт 2013 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

20.2.Энэ хуулийн 7.1 дэх хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ  
ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР  
НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, мөн зүйлийн 23.3.1 дэх заалтын “түүхий эд” гэсний өмнө “хүнснийхээс бусад” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “экспортлох эрх бүхий үйлдвэр” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.2.Хорио цээрийн улсын хяналт, шалгалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага /цаашид “хяналтын байгууллага” гэх/, хилийн боомт, гүний гааль бүхий газарт хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцааг тус тус хэрэгжүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “шошго жинхэнэ эсэхийг” гэснийг “шошго нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “мал эмнэлэг, ургамлын” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АРИУН ЦЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ариун цэврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:**

“13.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортолж, импортлоход энэ хуулийн 13.1 дэх хэсгийн заалт хамаарахгүй.”

#### **2/14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг:**

“14.5.Хуульд өөрөөр заагаагүй бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход энэ хуулийн 14.2, 14.3 дахь хэсгийн заалт хамаарахгүй.”

**2 дугаар зүйл.** Ариун цэврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “Үндэсний аюулгүй байдалд” гэсний өмнө “13.1.” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
 хот

### АЖ АХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.2.Хуульд заасан бол хүнсний чиглэлийн үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хучин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
 хот

### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1, 137.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“137.1.Хөдөлмөрийн удирдлагын тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага болон сум, хороонд хөдөлмөрийн ажилтан /хөдөлмөрийн алба/-аас бүрдэнэ.

137.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлагын дор ажиллана.”

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд дор дурдсан агуулгатай 25<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**“25<sup>1</sup> дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүрэг**

25<sup>1</sup>.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25<sup>1</sup>.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

25<sup>1</sup>.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах;

25<sup>1</sup>.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;

25<sup>1</sup>.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

25<sup>1</sup>.1.5.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой мэдээллийг төрийн байгууллага, ажил олгогчоос гаргуулан авах;

25<sup>1</sup>.1.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

25<sup>1</sup>.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг тухайн шатны хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга томилж, чөлөөлнэ.”



**2 дугаар зүйл.**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо болон аймаг, нийслэл, дүүргийн зэвлэл, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зэвлэл, ажилтнаас бүрдэнэ.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

#### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/29 дүгээр зүйлийн 29.9.9-29.9.12 дахь заалт:**

“29.9.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

29.9.10.мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;

29.9.11.жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;

29.9.12.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт

хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, хяналт тавих.”

#### 2/29 дүгээр зүйлийн 29.13.5 дахь заалт:

“29.13.5.хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг, дунд үйлдвэрийн талаарх хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих.”

**2 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6, 11.7 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “болон түүний эрх олгосон байгууллага” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсгийн “хөдөлмөр эрхлэлтийн ажилтан” гэсний дараа “хөдөлмөрийн алба” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 29.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“29.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцэн томилж, чөлөөлнө. Хөдөлмөрийн төв биржийн даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

29.4.Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтныг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга томилж, чөлөөлнө.”

**4 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9.9 дэх заалтын дугаарыг “29.9.13” гэж, 29.13.5 дахь заалтын дугаарыг “29.13.6” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалтын “, бодлого, зохицуулалтын шийдвэрийн талаар санал гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
 хот

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### 1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дахь заалт:

“4.1.9.“мэргэшлийн түвшин” гэж ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил, үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг.”

#### 2/6<sup>1</sup> дүгээр зүйл:

#### “6<sup>1</sup> дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн байгууллагын тогтолцоо

6<sup>1</sup>.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн байгууллагын тогтолцоо нь Зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төвөөс бүрдэнэ.”

#### 3/8 дугаар зүйлийн 8.4.21-8.4.23 дахь заалт:

“8.4.21. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах;

8.4.22. мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг баталж, менежерийг томилох, чөлөөлөх;

8.4.23. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.”

#### 4/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:

“8.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын хэрэгжилтийг хангах,

чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалт, судалгаа эрхлэх чиг үүрэгтэй байна.”

#### **5/16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг:**

“16.8. Энэ хуулийн 16.4-т заасан бичиг баримтын загвар, бичиг баримт бүрдүүлэх, олгох журмыг Зөвлөлийн саналыг үндэслэн хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

**2 дугаар зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн Хоёр дугаар бүлгийн гарчгийн “**удирдлага**” гэсний дараа “, **зохион байгуулалт**” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “**төрийн захирагааны**” гэсний дараа “**төв**” гэж, мөн зүйлийн 8.4.13 дахь заалтын “чөлөөлөх” гэсний дараа “, ажлын байрын тодорхойлолтыг батлах” гэж, 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “аж ахуйн нэгж” гэсний дараа “, иргэн” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “үнэлэх, дүгнэх журмыг” гэсний дараа “хөдөлмөрийн болон” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “түүнээс дээш зэрэгтэй,” гэсний дараа “эсхүл” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалт:**

“6.3.3. мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх талаар мэдээлэл, илтгэл, зөвлөмж гаргах, чиглэл өгөх;”

#### **2/8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт:**

“8.4.1. мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;”

#### **3/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3. Мэргэжлийн боловсрол, сургалт нь өдрийн, оройн, хосмог, хөдөлмөр эрхлэлтийн зэрэг хэлбэртэй байж болно.”

#### **4/12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэг:**

“12.10. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төлөөлөлд ажил олгогчийн төлөөлөл



байх ба удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**5/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:**

“14.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулах ба тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**6/16 дугаар зүйлийн 16.4.1-16.4.3 дахь заалт:**

“16.4.1.мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг албан болон албан бус сургалтын хэлбэрээр эзэмшиж, үнэлгээнд тэнцсэн иргэнд мэргэжлийн диплом;

16.4.2.суурь боловсрол эзэмшсэний дараа 2.5-аас доошгүй жил суралцаж мэргэжлийн болон бүрэн дунд боловсролыг хамтад нь эзэмшсэн иргэнд энэ хуулийн 16.4.1-д заасан бичиг баримтаас гадна бүрэн дунд боловсролын гэрчилгээ;

16.4.3.мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар олгох сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ.”

**4 дүгээр зүйл.**Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, мөн зүйлийн 6.7 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд” гэж, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “оловсролын” гэснийг “хөдөлмөрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

### БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 36.13 дахь хэсэг нэмсүгэй:

“36.13. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төлөөллийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “коллеж,” гэснийг “коллежид” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.12, 28.1.19 дэх заалтын “мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага,” гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “зөвшөөрөл шинээр олгохыг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл” гэснийг “зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэхийг Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталж, дагаж мөрдэх хүртэл” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар  
 хот

### Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудад заасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг 2013 оны 2 дугаар сард багтаан батлах;

2/энэ тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад заасан хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн актыг нийтэд таниулах, сургалт, сурталчилгааг сонирхогч талуудтай хамтран зохион байгуулах;

3/стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрлийн хураамж, түүний хэмжээг тогтоохтой холбогдсон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх саналаа 2013 оны 01 дүгээр сард багтаан Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Г.Баярсайхан/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн  
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад  
хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их  
Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1  
дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг  
хориглох бүлэг барааны жагсаалт"-ын 2 дахь заалтын "Бүх төрлийн спирт"  
гэснийг "Судалгаа, шинжилгээний зориулалттайгаас бусад этилийн спирт"  
гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Их Хурлын  
гишүүний бүрэн эрхийг хүлээн  
зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын  
Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын чуулганы  
хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 11.1.5  
дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цэрэндашийн  
Оюунбаатарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар  
хот

“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр  
нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай”  
тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолын 4 дэх заалтын “2013 оны 7 дугаар сарын 01-ний” гэснийг “2014 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар  
хот

Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг  
дэмжих зарим арга хэмжээний тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум /нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан баг малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулалт олгох;

2/хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох урамшуулалт шаардагдах хөрөнгийг 2013 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;

3/хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болон хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулалт олгох, түүнд хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

4/энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үйлдвэрлэгчид олгох зээлийн хүүг жилийн 7 хувиас илүүгүй байхаар тооцож олгох;

5/арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах.

3.“Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн” гэсэн тодотголыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2012 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 218

Улаанбаатар  
хот

**Орон тооны бус зөвлөхөөр томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Баяртын Пүрэвжавыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Байгаль орчны бодлогын орон тооны бус зөвлөхөөр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар  
хот

### Дипломат цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсад орчин үеийн дипломат алба үүсч хөгжсөний 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, гадаад бодлогын зорилт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оруулж ирсэн хувь нэмрийг нь өндөрөөр үнэлж, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Балдоржийн Даваадорж, Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Балдангийн Энхмандах нарт “Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цол хүртээж Мөнгөн гэрэгэ, энгэрийн тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохoon томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 3, “Дипломат албаны тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад хавсрсан суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пүрэвжавын Гансүхийг эгүүлэн татах,

Бүгд Найрамдах Филиппин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаа Банзрагчийн Дэлгэрмааг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар  
 хот

### Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд хэрэгжүүлэх улсын болон бус нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулан ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Д.Энхжаргал)-т, холбогдох баримт материалыг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2012 оны 131 дүгээр  
тогтоолын хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН 2013 ОНД ХЭРЭГЖКҮҮЛЭХ  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2013 онд санхүүжих
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА			
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА			



III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР				
IY	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА				
Y	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА				
YI	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БЛУГИЙН ДАРГА				
YII	ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА				
YIII	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА				
IX	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА				
X	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА				
XI	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА				
XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД		14,800.0	12,000.0	
XII.2	Төрийн тусгай хамгаалалтын газар		-	-	
XII.3	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар		14,800.0	12,000.0	
XII.3.1	Хөрөнгө оруулалт:		13,300.0	11,500.0	
XII.3.1.9	1 Иргэдийн өргөдөл гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем	2013	2014	1,300.0	500.0
XII.3.1.10	2 Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Аймаг, нийслэл /	2013	2013	6,000.0	6,000.0
XII.3.1.16	3 Цахим систем болон Мобайл технологид сууринсан программ хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх	2013	2014	5,000.0	4,000.0
XII.3.1.17	4 Төрийн бургалт мэдээллийн нэгдсэн тогтолцоо, доодот сүлжээг бүрэн нэвтрүүлэх	2013	2013	1,000.0	1,000.0
XII.3.2	ТЭЗҮ, зураг төсөл:			1,500.0	500.0
XII.3.2.2	5 Тандан судалгааны хиймэл дагуулын газрын станц байгуулах	2013	2014	1,500.0	500.0
XIII	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД			10,931.7	7,551.8
XIII.1	Онцгой байдлын ерөнхий газар			5,120.0	2,620.0
XIII.1.1	Хөрөнгө оруулалт:			5,000.0	2,500.0
XIII.1.1.10	6 Улсын нөөцийн "Объект-03" салбарын иж бүрэн агуулах /Улаанбаатар/	2013	2014	4,000.0	2,000.0
XIII.1.1.11	7 Улсын нөөцийн Шатахууны салбарын агуулахын шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	1,000.0	500.0
XIII.1.4	ТЭЗҮ, зураг төсөл:			120.0	120.0
XIII.1.4.1	8 Хүнсний бараа, материал хадгалах иж бүрэн механизсан агуулахын зураг төсөл	2013	2013	120.0	120.0
XIII.2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар			4,506.2	3,626.3
XIII.2.1	Хөрөнгө оруулалт:			1,579.9	700.0
XIII.2.1.1	9 Аймгийн мэргэжлийн хяналтын газрын лаборатори /Ховд/	2013	2014	970.0	400.0
XIII.2.1.2	10 Аймгийн мэргэжлийн хяналтын газрын лаборатори /Төв/	2013	2014	609.9	300.0
XIII.2.2	Тоног төхөөрөмж:			2,926.3	2,926.3
XIII.2.2.1	11 Термокамер, хяналтын камер	2013	2013	500.0	500.0
XIII.2.2.2	12 Мэргэжлийн хяналтын байцаагчдын багаж хэрэгсэл	2013	2013	868.0	868.0



XIII.2.2.3	13	Мэргэжийн хяналтын лабораторийн тоног төхөөрөмж	2013	2013	1,558.3	1,558.3
XIII.3		Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв			505.5	505.5
XIII.3.1		Хөрөнгө оруулалт:			265.5	265.5
XIII.3.1.1	14	Шалгалт тохицууллын лаборатори байгуулах	2013	2013	265.5	265.5
XIII.3.3		Тоног төхөөрөмж:			240.0	240.0
XIII.3.3.1	15	Төв, орон нутгийн хэмжил зүйн лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл	2013	2013	240.0	240.0
XIII.4		Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар			400.0	400.0
XIII.4.2		Тоног төхөөрөмж:			400.0	400.0
XIII.4.2.3	16	Хэрэглэгчийн лаборатори байгуулах шинхилгээ, судалгааны тоног төхөөрөмж	2013	2013	400.0	400.0
XIII.5		Оюуны өмчийн газар			-	-
XIII.6		Худалдан авах ажиллагааны газар			400.0	400.0
XIII.6.1.1	17	Тээврийн хэрэгслэл	2013	2013	147.0	147.0
XIII.6.1.2	18	Компьютер, тоног төхөөрөмж	2013	2013	97.0	97.0
XIII.6.1.3	19	Тавилга, эд хогшил	2013	2013	156.0	156.0
XIY		ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА				
XY		ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД				
XYI		САНГИЙН САЙД			12,622.3	6,134.8
XYI.1		Сангийн яам			3,522.3	734.8
XYI.1.1		Хөрөнгө оруулалт:			3,522.3	734.8
XYI.1.1.2	20	АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Бус нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх" төслийн дотоод эх үүсвэр	2013	2016	3,522.3	734.8
XYI.2		Татварын ерөнхий газар			5,800.0	2,100.0
XYI.2.3		Тоног төхөөрөмж:			5,800.0	2,100.0
XYI.2.3.1	21	Цахим татвар программ хангамж, техник, тоног төхөөрөмж худалдан авах, сургалттай сайжруулах /Улаанбаатар/	2013	2015	5,800.0	2,100.0
XYI.3		Гаалайн ерөнхий газар			3,300.0	3,300.0
XYI.3.1		Хөрөнгө оруулалт:			3,300.0	3,300.0
XYI.3.1.3	22	Шивээхүрэн боомтод 32 айлын орон сууц барих /Өмнөговь/	2013	2013	1,500.0	1,500.0
XYI.3.1.4	23	8 айлын орон сууц нийт 24 айлын орон сууц 3 байршилд барих /Сүхбаатар, Бичигт, Ховд, Булган, Хөвсгөлийн Мөрөн/	2013	2013	1,800.0	1,800.0
XYII		ХУУЛЬ ЗҮЙН САЙД			22,788.1	14,137.5
XYII.1		Цагдаагийн ерөнхий газар			13,088.2	8,525.2
XYII.1.1		Хөрөнгө оруулалт:			10,460.8	5,897.8
XYII.1.1.3	24	Дотоодын цэргийн 805-р ангийн усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын албаны контор, цэргийн гал зуухын нэгдсэн байр /Улаанбаатар, Баянзүрх/	2013	2013	1,700.0	1,700.0
XYII.1.1.4	25	Дотоодын цэргийн бэлтгэл хүчиний болон 809-р тусгай салбарын нэгдсэн барилга /Улаанбаатар, Баянзүрх/	2013	2013	1,197.8	1,197.8
XYII.1.1.5	26	Мөрдөн байцаах газрын барилга /Улаанбаатар, Чингэлтэй/	2013	2014	7,563.0	3,000.0
XYII.1.3		Тоног төхөөрөмж:			2,627.4	2,627.4
XYII.1.3.1	27	Цагдаагийн байгууллагын автопарк шинэчлэл	2013	2013	1,627.4	1,627.4



## ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2013 он №02 /767/

XYII.1.3.2	28	Холбоо, сүлжээний техник хэрэгсэл	2013	2013	1,000.0	1,000.0
XYII.2		Хил хамгаалах ерөнхий газар			5,844.4	1,756.8
XYII.2.1		Хөрөнгө оруулалт:			3,980.0	1,300.0
XYII.2.1.2	29	Хилийн ангийг шилжүүлэн байршуулах /Дорноговь, Хатанбулаг/	2012	2014	3,980.0	1,300.0
XYII.2.2		Тоног төхөөрөмж:			1,864.4	456.8
XYII.2.2.1	30	Салбар нэгжийн агсамж, хамгаалалтын нэг бүрийн хэрэгсэл, зэвсэг	2012	2013	1,864.4	456.8
XYII.3		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар			3,855.5	3,855.5
XYII.3.1		Хөрөнгө оруулалт:			3,855.5	3,855.5
XYII.3.1.2	31	Хорих ангиний байр /Улаанбаатар, Нийтийн/	2013	2013	3,855.5	3,855.5
XYII.4		Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар				
XYII.5		Архивын ерөнхий газар				
XYII.6		Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг				
XYII.7		Дотоод хэргийн сургууль				
XYIII		ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			100,341.6	57,311.1
XYIII.1		Цахилгаан дамжуулах шугам, дэд станцууд			41,265.7	26,337.6
XYIII.1.17	32	Хархорин, Мөрөн дэд станцад тус бүр 2 ком 6, 10 кВ-ын удирдлагатай реактор, Сайншанд дэд станцад 2 ком 35 кВ-ын синхрон компенсатор сууринуулах /Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь/	2012	2013	720.0	720.0
XYIII.1.20	33	Халиун-Цээл сумын 35 кВ-ын 31.4 км, 15 кВ-ын 84.45 км ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	2012	2013	2,214.0	2,184.2
XYIII.1.34	34	Сумдын 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станцын иж бүрэн шинэчлэл	2012	2013	5,000.0	5,000.0
XYIII.1.39	35	Төвийн бусийн эрчим хүчиний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/	2013	2014	1,598.3	800.0
XYIII.1.40	36	Мандал сумын Хэрх тосгон 35/6 кВ-ын дэд станц барих /Сэлэнгэ/	2013	2013	463.4	463.4
XYIII.1.41	37	Баянхонгор суманд шинээр баригдах "Хонгор-1000" орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн 6 кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих /Баянхонгор/	2013	2014	1,000.0	500.0
XYIII.1.42	38	Улаанбаатар хотын 13 хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн сайжрууллах /Улаанбаатар/	2013	2014	8,100.0	4,000.0
XYIII.1.43	39	"Булган хангай" хорооллыг дулаан, цахилгааны эрчим хүчээр хангах /Архангай/	2013	2013	1,800.0	1,800.0
XYIII.1.44	40	Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2013	2014	6,880.0	3,880.0
XYIII.1.45	41	Сумын 15 кВ-ын 61 км ЦДАШ, дэд станц барих /Баянхонгор, Шинэжинст, Баянцагаан/	2013	2014	1,800.0	800.0
XYIII.1.46	42	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Ховд, Жаргалант/	2013	2013	1,750.0	1,750.0
XYIII.1.47	43	Багуудыг цахилгаан дамжуулах дэд станцад холбоо /Баян-Өлгий/	2013	2013	940.0	940.0
XYIII.1.48	44	"Чойр дэд" станцыг өргөтгөх автотрансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Рөлөй хамгаалалтын автоматын шинэчлэл	2013	2014	9,000.0	3,500.0



ХҮIII.2		Дулааны цахилгаан станц, дулааны шугам			43,213.7	19,815.3
ХҮIII.2.4	45	ДЦС-2-ын зуухны шинэчлэл /Улаанбаатар/	2012	2013	3,000.0	3,000.0
ХҮIII.2.15	46	Дулааны сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн, Төв зах, Гурван Эрдэнэ сургууль, Зүүн талын шинэ хороолол/	2012	2014	5,000.0	1,500.0
ХҮIII.2.17	47	Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх/	2013	2014	3,172.1	1,500.0
ХҮIII.2.18	48	Дулааны станцын K1, K2 зуухны засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Шарьин гол/	2013	2013	465.3	465.3
ХҮIII.2.19	49	ДЦС-2-ын цахилгаан тоноглолын шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	2,430.1	1,000.0
ХҮIII.2.20	50	Дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх /Сэлэнгэ, Сухбаатар/	2013	2014	1,492.6	750.0
ХҮIII.2.21	51	ДЦС-2-ын ПТ-12-35 турбины тохируулгын блок солж шинэчлэх /Улаанбаатар/	2013	2013	500.0	500.0
ХҮIII.2.22	52	ДЦС-ын 12 МВт-ын турбины тохируулгын блок, тулах холхивчудын шинэчлэл /Дархан-Уул, Дархан/	2013	2013	550.0	550.0
ХҮIII.2.23	53	Шинээр баригдах орон сууцны 11,12,13-р хороолол руу дулааны шугам шинээр тавих, хуучин шугамыг өргөтгөх /Дархан-Уул, Дархан/	2013	2014	1,711.4	900.0
ХҮIII.2.24	54	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг ул хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур/	2013	2014	3,880.9	2,400.0
ХҮIII.2.25	55	ДЦС-2-ын ТС-35-39 зуух №1, 3-д үнс барих цахилгаан шүүлтүүр сууринтуулах /Улаанбаатар/	2013	2013	1,000.0	1,000.0
ХҮIII.2.26	56	6д магистралын Тк-639-өөс Тк-643 хүртэлх 1223 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	2,548.5	1,250.0
ХҮIII.2.27	57	2 г, д магистралын Тк-226-аас Тк-234 хүртэлх 1400 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	1,531.5	1,000.0
ХҮIII.2.28	58	Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн/	2013	2015	15,931.3	4,000.0
ХҮIII.3		Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах			5,000.0	5,000.0
ХҮIII.3.3	59	ДЦС-4-т зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах технологи нэвтрүүлэх /Улаанбаатар/	2012	2013	5,000.0	5,000.0
ХҮIII.4		Гадаадын зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр			6,400.0	2,900.0
ХҮIII.4.3	60	Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Эрчим хүчиний төслийн нэмэлт санхүүжилт" төслийн дотоодын эх үүсвэр	2010	2013	6,400.0	2,900.0
ХҮIII.5		Эрчим хүчиний яам			4,462.2	3,258.2
ХҮIII.5.1		Хөрөнгө оруулалт:			258.2	258.2
ХҮIII.5.1.1	61	Химиийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Улаанбаатар/	2012	2013	258.2	258.2
ХҮIII.5.2		Их засвар:			604.0	300.0
ХҮIII.5.2.1	62	Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторийг шинээр байгуулах /Улаанбаатар/	2013	2014	604.0	300.0



## ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2013 он №02 /767/

ХҮIII.5.3		ТЭЗҮ, зураг төсөл:			3,600.0	2,700.0
ХҮIII.5.3.3	63	ДЦС-5-ыг Сонгино 220/110/35 кВ, Улаанбаатар 220/110/35 кВ дэд станцуудтай холбох 220 кВ-ын 2 халхээт ЦДАШ-ын ТЭЗҮ, зураг төсөв хийц /Улаанбаатар/	2013	2013	400.0	400.0
ХҮIII.5.3.4	64	Тамсаг-Халх голын 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /Дорнод/	2013	2013	250.0	250.0
